

Шинэчлэн сайжруулж буй Хотын логистик хичээлийн хөтөлбөрт өгөх санал

2022.09.22

1. Хичээлийн хөтөлбөрийн баримт бичиг МУИС-т мөрдөгдөж буй баримт бичгийн загвараас өөр байгаа тул засварлах шаардлагатай. (Хичээлийн хөтөлбөр дээр тэмдэглэсэн болно).
2. Хичээлийн зоилго, ач холбогдол тодорхойгүй бичигдсэн. Дэлгэрүүлэн зөв томъёолж бичих шаардлагатай.
3. Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, дадлыг (CLO) хичээлийн агуулгатай бараг ижил томъёолсныг засварлах, тавигдах шаардлагын дагуу зөв тодорхойлох шаардлагатай
4. Хичээл заах арга барил гэж оруулсан нь мөн хэт ерөнхий, тодорхойгүй байна. Шаардлагатай бол сэдэвчилсэн төлөвлөгөөнд хичээл явагдах хэлбэрийг тусгаж болно.
5. Үнэлгээний хуваарилалт дидактик талаас хэр нийцтэй эсэхэд эргэлзэж байна. Хэрэв ийм байх нь тохиромжтой гэж үзэж буй бол давхар тайлбар ирүүлбэл сайн байна. Тухайлбал ирцийн оноо хэт өндөр, улирлын шалгалтыг бие даалтаар орлуулж байгаа зэрэг нь хэр зохистой вэ? Цахим сургалтанд ийм байх шаардлага, журам бий юу?
6. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөг МУИС-д мөрдөж буй маягтын дагуу хийх, ингэхдээ хичээл бүрт хэрэглэгдэх сурах бичиг, материалыг зааж өгөх шаардлагатай
7. Семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд даалгавар, бодлого тооцоог төлөвлөж оруулах хэрэгтэй.
8. Зарим техник алдаа байгааг хянаж засварлах хэрэгтэй.

Санал бичсэн:

ХБООИТ-ийн ХБОИ хөтөлбөрийн дэд профессор



Ц.Соёл-Эрдэнэ